

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 08 сарын 11 -ны өдөр

Дугаар.....

БА-074/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянгол дүүргийн 1 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 17 (арван долоо) автомашины дулаан зогсоолтой, 84 (наян дөрөв) айлын хүчин чадалтай үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/03/17 огноо, 0012367, БАЗГ2023/053 дугаар,

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: Е.Г.Шифр: АЕС-10/22,

2.3. Захиалагч: Сайрам булган ХХК оноосон нэр, 000165746 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5098289 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 1 дүгээр хороо, 226-р байр, 99996020 холбоо барих утас, ondoo_6020@yahoo.com цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Эм Си Эл констракшн ХХК оноосон нэр, 9019013004 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2822555 регистрийн дугаар, БУ11-1351/18 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6 дугаар хороо, 10-р хороолол, Зол хайрхан ХХК-ийн байр, 89118783 холбоо барих утас;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Агниста инженеринг ХХК оноосон нэр, 9011458050 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5794021 регистрийн дугаар, ЗТ19-93/22 Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, 2-р 40 мянгат, бзи 25-24 байр, 99068114 холбоо барих утас;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Сайрам булган ХХК оноосон нэр, 000165746 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5098289



регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 1 дүгээр хороо, 226-р байр, 99996020 холбоо барих утас;

Богд асар Инженеринг ХХК оноосон нэр, 9011476140 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5833868 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 1 дүгээр хороо, ба-42 тоот, 91913863 холбоо барих утас;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангасан тул

3.1. Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 17 (арван долоо) автомашины дулаан зогсоолтой, 84 (наян дөрөв) айлын хүчин чадалтай үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.


3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;



- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.


Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 17 (арван долоо) автомашины дулаан зогсоолтой, 84 (наян дөрөв) айлын хүчин чадалтай үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжид ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Сайрам булган ХХК-ийн захиалгатай, зорьтой 16 давхар 1 блок, 17 (арван долоо) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 84 (наян дөрөв) айлын орон сууцны барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
Бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:
Захиалагч Сайрам булган ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



(А.Мөнгөн)



(Т.Хаш-Эрдэнэ)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 1 ДҮГЭЭР ХОРОО, САЙРАМ БУЛГАН ХХК-ИЙН
ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 16 ДАВХАР 1 БЛОК, 17 АВТОМАШИНЫ ДУЛААН
ЗОГСООЛТОЙ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 84 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 12

Улаанбаатар хот
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Сайрам булган ХХК-ийн захиалгатай, зоорьтой 16 давхар 1 блок, 17 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 84 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 16 дугаар давхарт 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр 09:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11:00 цагт дуусав.

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мөнгөн
2. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Ц.Алтансүх
3. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Э.Цогзолмаа
4. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын ахлах инженер Б.Дашдорж
5. Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга Д.Сүхбат
6. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер Б.Жамбалцанжид
7. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Уранчимэг
8. Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Дэд хурандаа М.Батсайхан
9. Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн О.Ундрах
10. Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивч Н.Өлзийжаргал
11. Ашиглалтын Богд Асар Инженеринг ХХК-ийн захирал Д.Анхжаргал
12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллага Б.Болормаа
13. Захиалагч Сайрам булган ХХК-ийн гүйцэтгэх захирал Т.Хаш-Эрдэнэ
14. Зураг төслийн Агниста инженеринг ХХК-ийн ерөнхий инженер Б.Ганбаяр
15. Гүйцэтгэгч Эм Си Эл констракшн” ХХК-ийн даамал Б.Цэвээнравдан

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Сайрам булган ХХК-ийн захиалгатай, зoorьтой 16 давхар 1 блок, 17 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 84 айлын орон сууцны барилга байгууламжийг ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч **Ц.Алтансүх:**

- Бетоны шинжилгээний дүнг нөхөж шалгуулах
- БАЗГ-г шалгуулах, тайлбар ирүүлэх
- Зоорь, 1 болон 2-р давхрын ажлын дутууг гүйцээх тайлбар, баримт ирүүлэх /Батлагдсан ЗТ-г өгөх/
- Өөрчлөлтийн зургийг нөхөж шалгуулах
- Техникийн давхрын заслал чимэглэлийг гүйцээх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа:**

- Холигч дулааны узелийн тоног төхөөрөмж, шугам сүлжээг хаягжуулж, фото зургаар баталгаажуулах
- Халаах хэрэгслүүд дээр термостат вентель суурьлуулах
- 1 болон 2 давхрын агааржуулалтын системийг бүрэн угсарч дуусгах, дуу чимээний хэмжилтийн дүнгийн хамт баталгаа албан тоот ирүүлэх
- Дээвэр дээрх АС-н шахтнаас бохирын хоолойг өндөрлөж фото зургаар баталгаажуулж ирүүлэх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, техник хяналтын ахлах инженер **Б.Дашдорж:**

- Гадна цахилгаан, дэд өртөөний гүйцэтгэлийн бичиг баримт, холбогдох бичиг баримт байхгүй
- Дэд өртөөний эрчим хүчний хамгаалалтын зурваст барилга баригдсан
- Залгах зөвшөөрөлгүй дэд өртөөг залгасан. Үүнд эрчим хүчний улсын байцаагчийн арга хэмжээ тооцуулах
- 0,4 кВ-ын щитний барилгын заслын ажил дуусгах, хаяг, бичлэг биржжүүлэлт АА-ны плакат хадах
- Давхрын коридорт айлуудын дугаар, хаяг хадах



- Аянгын тор зургийн дагуу гүйцэтгэж фото зураг шалгуулах
- Үйлчилгээний хэсгийн дутуу ажлуудыг гүйцэтгэж фото зургаар шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авахаас татгалзсан саналтай байна.

Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга

Д.Сүхбат:

- Халаах хэрэгсэлд тохируулах хаалт тавих
- Холигч насосны узельд хаягжуулалт хийх
- УДДТ-д тоног төхөөрөмжийн өргөлтөл хийсэн талаар мэдээлэл дүгнэлтэд тусгаж өгөх
- Цэцэрлэгийн хашаанд хийсэн худгийг засварлах, шинэчлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Б.Жамбалцанжид:**

- Гадна цэвэр усны ажлын зургийн өөрчлөлт дээр зургийн авторын дүгнэлт, тайлбар бичиг өгөх
- Усны тоолуурыг доош нь буулгах
- Усны нөөцийн санг халдваргүйжүүлэлт хийлгэж, дээж өгч шинжилгээ өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Э.Уранчимэг:**

- Зурагт 8 тв-4ш суурилуулах гэж өгөгдсөн. 8 тв-н Hard-2ш суурилуулсан байна. 2ш нэмж суурилуулах /зургийн дагуу/
- Камеруудыг бүрэн ажиллагаанд оруулах /1-3 давхар/. Зургийн дагуу камеруудыг суурилуулах
- Давхрын самбаруудын кабелиудыг цэгцлэх, фото зургаар баталгаажуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Дэд хурандаа **М.Батсайхан:**

- Дутуу хийгдсэн галын дохиолол, мэдээлэгчийг гүйцээх
- Зоорийн давхарт буусан цахилгаан шатны гонх хаалтны 1 хаалга хийх
- 2-р давхрын шатны хонгилын хаалга хийх
- Гал унтраах автомат спринклерийн системийн төгсгөлд даралт хэмжигч хийх, шалгаж туршаад видео бичлэг ирүүлэх
- ГК галын дотор усны даралтат цэгийг даралттай усаар хангах
- Усны нөөцийн савыг батлагдсан зураг төслийн дагуу болгох
- Шатны хонгилын хаалганд өөрөө хаагч тоноглол хийх
- Нийтийн эзэмшлийн дотор хананы материалд зохиогч тайлбар албан бичгээр өгөх
- Зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийсэн тэмдэг дарсан хуудас нөхөж үзүүлэх

НАЛТ Ш
ГАЗ
байгуулам
оруула

- Гадна хананы гал тэсвэрлэлтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт үзүүлэх. Материалд хавсаргах.
- Шаталтын бүтээгдэхүүн сорох, даралттай агаар өгөх системийн автоматжуулалт хийх.
- Гал унтраах хөдөлгөөнт техник цэнэглэх, гадна гидрант хийх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн **О.Ундрах:**

- Ажлын зурагны В1 давхраас 16 давхар хүртэл байгуулалтын батлагдсан эх зургийг нөхөж үзүүлэх
- БТХ-ийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж төлөх
- Дулаан зосгоолын шалны нягтруулалттай холбоотой шалны хагарлыг засварлах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн архивч **Н.Өлзийжаргал:**

- Ажил гүйцэтгэх гэрээ /ерөнхий гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч компаниудын гэрээг/
- ОБЕГ-н дүгнэлт, зохиогчийн дүгнэлт, лифтний дүгнэлтийн эх хувийг хувийн хэрэгт хавсаргах
- Барилга угсралтын ил, далд ажлын актыг бүрэн бүрдүүлэх
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийг баталгаажуулах
- Архивд баримт хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй бүрдүүлж, бичвэртэй хуудас бүрийг дугаарлаж, дотоод товъёг үйлдэх
- Баримт бичгийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх
- Зоорийн давхраас-16 давхрын байгуулалтын батлагдсан зургийг нөхөж үзүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ашиглалтын Богд Асар Инженеринг ХХК-ийн захирал **Д.Анхжаргал:**

- Барилгын зураг, акт, холбогдох бусад баримт бичгүүдийг хүлээлгэн өгөх
- Шинэ материалын заавар зааварчилгаа, сургалт авах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах байгууллага **Б.Болормаа:**

- Үйлчилгээрүү орсон налуулалт хийх, фото зураг
- Орцруу ордог пандусыг стандартын дагуу хийх, мөн орцруу орох налуу зам хийх, фото зураг
- Гаднах авто зогсоолд ХБИ-д зориулсан хэвтээ болон босоо тэмдэглэгээг хийж дуусгах, фото зураг
- Үйлчилгээний 1, 2 давхрын ариун цэврийн өрөөнүүдэд ХБИ-д зориулсан тоноглол хийх, фото зураг

- В1 давхраас лифтруу орох пандусыг стандартын дагуу хийж дуусгах
Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Зураг төслийн Агниста инженеринг ХХК-ийн ерөнхий инженер **Б.Ганбаяр:**

- Авто зогсоолын шаланд хэв гажилтын зүсвэр хийх /cutting joint/

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Гүйцэтгэгч Эм Си Эл констракшн ХХК-ийн даамал **Б.Цэвээнравдан:**

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Захиалагч Сайрам булган ХХК-ийн гүйцэтгэх захирал **Т.Хаш-Эрдэнэ:**

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн:**

- БНБД 11-04-06 Зохиогчийн дүгнэлтийг шинэчлэн бичих
- Зохиогч, гүйцэтгэгч томилгоог албажуулан ирүүлэх
- Гүйцэтгэгч БТХ-ийн 14.3, 14.6-ын дагуу чанарын баталгаа ирүүлэх
- Дулаан зогсоолын тоо 17 /баталсан зураг/ албан бичиг ирүүлэх
- 1,2-р давхрын үйлчилгээний талбайн дотор заслыг бүрэн дуусгах (фото)
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг хангах


Татгалзах санал гаргав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Сайрам булган ХХК-ийн захиалгатай, зоорьтой 16 давхар 1 блок, 17 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 84 айлын орон сууцны барилгыг ашиглалтанд оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Сайрам булган ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



(Т.Хаш-Эрдэнэ)